



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 7/185

Чингис хот

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.5, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг адил тэгш эрхтэйгээр нийгэм хамт олонд хамруулах, тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Тэмүүлэл-13" урлагийн наадамд оролцогч хүүхдүүдэд өгөх гарын бэлгийн зардалд 500.000 /таван зуун мянган төгрөг/-ийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

05 Аймгийн Засаг даргын 2018 оны  
дугаар сарын 29 өдрийн 41185  
дугаар захирамжийн хавсралт



**“Тэмүүлэл-13” урлагийн их наадамд оролцогчдын бэлэгний төсөв**

№	Барааны нэр	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Ундаа	1200	50 ширхэг	60000
2	Шоколад	2500	50 ширхэг	125000
3	Чипс	1000	50 ширхэг	50000
4	Хөөсан чихэр	2300	50 ширхэг	115000
5	Шагшуурга	2000	50 ширхэг	100000
6	Печень	1000	50 ширхэг	50000
<b>Нийт</b>				<b>500.000</b>